

 lendmn

“ЛэндМН ББСБ” ХК

2021 оны II улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



7707-0101

www.fb.com/LendMN

www.lend.mn

#АсааАсуудлааШийд



Агуулга

I. Зээлийн үйл ажиллагаа	06
II. Бизнесийн үйл ажиллагаа	09
III. Харилцагчийн үйл ажиллагаа	16
IV. Санхүүгийн үйл ажиллагаа	18
V. Эрсдлийн удирдлага	21
VI. Компанийн засаглал	24



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

“Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд”-ыг 2 дахь жилдээ амжилттай гаргалаа.”

Сайн байна уу?

Эрхэм хүндэт харилцагчид, түнш, хамтрагч байгууллагууд болон бидэнд итгэл хүлээлгэн үргэлж дэмжин ажилладаг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхнийхээ энэ өдрийн амар мэндийг эрэн мэндчилж байна.

Дэлхий даяар болон Монгол улсад Ковид-19 цар тахал хурдацтай тархаж, эрсдэл өндөртэй, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн энэхүү хариуцлагатай цаг үед Дижитал хөрөнгө оруулалт уриатайгаар “ЛэндБонд”-ыг хөрөнгийн зах зээлд 2 дахь жилдээ амжилттай гаргаж, олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээ. 2020 онд олон нийтэд нээлттэй санал болгосон “ЛэндБонд” нь татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүнгээс 34.8%-иар давж биелсэн бол 2 дахь жилдээ нээлттэй санал болгосон “ЛэндБонд” нь 51.7%-иар давж биелсэн нь хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг хүлээсэн, үнэт цаасны зах зээлд өөрийн байр суурийг эзэлсэн брэнд БОНД болж чадсаныг илтгэж байна.

Монголд анх удаа Дэлхийн №1 crypto exchange Binance дээр LendMN аппликейшн P2P төлбөрийн хэрэгслээр нэмэгдсэн мэдээг харилцагч та бүхэндээ дуулгахад таатай байна. Өнөөгийн өсөн нэмэгдэж, хурдтай хөгжиж буй крипто арилжаанд оролцогчдын хувьд өөр хоорондоо крипто арилжаалах хүсэлт үүсгэж, төлбөрийн асуудлаа LendMN аппликейшнээр хялбархан шийдэж төгрөгөөр гүйлгээ хийх боломж бүрдлээ.

Компанийн гаргасан хувьцааны ханшийг тогтворжуулах зорилгоор өөрийн гаргасан хувьцааг үргэлжлүүлэн худалдаж авах шийдвэрийг дахин гаргаж, Хувьцаагаа эргүүлэн худалдан авах хоёр дахь хөтөлбөрийг дахин зарлалаа. Энэ нь хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалах, хөрвөх чадвар муудсан үед нөөц хөрөнгө гарган хөрөнгийн эргэх чадварыг нэмэгдүүлэхэд

хувь нэмрээ оруулах, нэгж хувьцааны ханш өсөх зэрэг чухал ач холбогдолтой юм. Мөн “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан 4,765 хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд ногдол ашгийг байршууллаа.

ЛэндМН нь тогтвортой санхүүгийн зарчим, стандарт хэрэгжүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд хамтран ажиллах зорилгоор ToC Холбоо / MSFA-нд Үндсэн гишүүнээр нэгдлээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 вируст цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх багц арга хэмжээг МОНГОЛБАНК-аас хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор ЛэндМН нь Зээлийн Мэдээллийн Санд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн түүхтэй харилцагчдынхаа зээлийн ангилалд өөрчлөлт оруулах боломжтой боллоо. Ингэснээрээ Харилцагчдын чанаргүй зээлийн ангилал засагдах боломж бүрдлээ.

Монгол улсын хэмжээнд цар тахлаас шалтгаалсан эдийн засаг хүндрэлтэй байгаа энэхүү нөхцөлд харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цахим зээлийн үйлчилгээгээ үргэлжлүүлэн хэвийн олгож байгаа бөгөөд хөдөө орон нутаг, аймгуудад ч гэсэн зээлийн гэрээ байгуулах цэгүүд, нотариатуудыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Харилцагчдадаа зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олгосоор байгаа төдийгүй, шинэ харилцагчид маань LendMN аппликейшнээрээ дамжуулан өөрт хамгийн ойрхон байршлуудаас сонгон, цахим зээлийн гэрээгээ нэг удаа байгуулаад хүссэн үедээ хэзээ ч, хаанаас ч хэрэглээний барьцаагүй зээлийн үйлчилгээгээ авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. “ЛэндМН ББСБ” ХК нь нийт харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2021 оны II улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

01




Зээлийн үйл ажиллагаа

2021 оны II улиралд нийт 40.4 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 195.1 мянган зээлийг LendMN харилцагчдадаа дамжуулан олголоо. Ингэснээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн харилцагчдадаа олгосон нийт зээлийн хэмжээ 870.4 тэрбум төгрөг, нийт олгосон зээлийн тоо 4.1 саяд хүрсэн байна.

2021 оны II улирлын үзүүлэлтүүдийг өмнөх тайлант үетэй харьцуулсан байдал


Гэрээт харилцагчийн тоо

(Өссөн дүнгээр, мянган харилцагч)



Нийт олгосон болон сунгасан зээлийн тоо


(мянган зээл)



■ Олгосон зээл ■ Сунгасан зээл

Нийт олгосон болон сунгасан зээлийн дүн


(тэрбум төгрөг)



■ Олгосон зээл ■ Сунгасан зээл

Цэвэр зээлийн багц

(тэрбум төгрөг)



Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2021 оны II улиралд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хатуу хөл хориог бууруулснаар зээлийн багцын чанарын үзүүлэлт түүнийг дагаад сайжирсан буюу чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 7% болж буурсан байна. Түүнчлэн энэ улиралд зээлийн эрсдэлийн сангийн зардал 300 гаруй саяар буурч, 2.7 тэрбум төгрөгт хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 135.3%-д хүрсэн байна.

Тэрбум төгрөг	2020.IV	2021.I	2021.II
Нийт зээлийн багц	28.1	30.6	28.4
Зээлийн эрсдэлийн сан	(3.3)	(3.0)	(2.7)
Цэвэр зээлийн багц	24.8	27.6	25.7
Хэвийн зээл	25.0	27.8	26.0
Хугацаа хэтэрсэн зээл	0.5	0.6	0.4
Чанаргүй зээл	2.6	2.2	2.0
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	9.1%	7.3%	7.0%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	130.4%	135.7%	135.3%

02



Бизнесийн үйл ажиллагаа

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд”-ыг 2 дахь жилдээ амжилттай гаргалаа

“ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлд 2 дахь жилдээ 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “ЛэндБонд”-ыг амжилттай гаргалаа.

Монголын финтек салбарын тэргүүлэгч компани болох “ЛэндМН ББСБ” ХК нь 2021 оны 6 сарын 25-наас 30-ны хооронд олон нийтээс нээлттэйгээр захиалга авсан бөгөөд нийт 505 хөрөнгө оруулагчдаас 7,583,500,000 төгрөгийн захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 51.7%-иар давж биеллээ.

Энэхүү бонд нь компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн санхүүжүүлэлтэд зарцуулагдах бөгөөд бонд нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 14%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, 6 сар тутамд хүү төлөх давтамжтай байх юм.

2020 онд олон нийтэд нээлттэй санал болгосон “ЛэндБонд” нь татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүнгээс 34.8%-иар давж биелсэн бол 2 дахь жилдээ нээлттэй санал болгосон “ЛэндБонд” нь 51.7%-иар давж биелсэн нь хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг хүлээсэн, үнэт цаасны зах зээлд өөрийн байр суурийг эзэлсэн брэнд БОНД болж чадсаныг илтгэж байна.


Энэ жилийн онцлог бол цар тахлын эрсдэлтэй энэ цаг үед Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” уриатайгаар захиалгыг онлайнар SuperUp аппликейшнээр дамжуулан авсан явдал юм. Мөн харилцагчид өөрийн үйлчлүүлдэг болон аль ч үнэт цаасны компаниар дамжуулж захиалга өгөх боломжтой байсан ба “ЛэндБонд”-ын андеррайтераар “Өлзий Энд Ко Капитал ҮЦК” ХХК, синдикатаар “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ууд ажиллалаа.

Бидэнд итгэж хөрөнгө оруулсан нийт хөрөнгө оруулагчдадаа баярлалаа.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд

#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав





Дэлхийн №1 crypto exchange Binance дээр LendMN P2P төлбөрийн хэрэгслээр нэмэгдлээ

Монголд анх удаа Дэлхийн №1 crypto exchange Binance дээр LendMN аппликейшн P2P төлбөрийн хэрэгслээр нэмэгдлээ.

Монголын хэрэглэгчид Binance P2P дээр LendMN-ийг ашиглан төгрөгийн гүйлгээ хийж, крипто худалдаж авах, борлуулах боломжтой боллоо.

Өнөөгийн өсөн нэмэгдэж, хурдтай хөгжиж буй крипто арилжаанд оролцогчдын хувьд өөр хоорондоо крипто арилжаалах хүсэлт үүсгэж, төлбөрийн асуудлаа LendMN-ээр хялбархан шийдэж төгрөгөөр гүйлгээ хийх боломж бүрдлээ.

Binance P2P гэж юу вэ?

P2P гэдэг нь иргэд хоорондын гүйлгээ болон арилжааг төлөөлөх нэршил юм. P2P гүйлгээ болон арилжаа нь иргэдэд шилжүүлгийн шимтгэлгүй зах зээлд оролцох боломж олгодог. Энэ нь брокер, биржээс худалдан авахаас хямд, худалдан авах үнэ, шимтгэлээ сонгон авах боломж олгодог. Гэхдээ иргэд хоорондын гүйлгээнд үүсч болох луйвар, залилангаас сэргийлэх үүднээс P2P үйлчилгээний нөхцлүүдийг сайтар нягталж, эрсдлээс зайлсхийх хэрэгтэй. Binance-аас санал болгож буй Binance P2P үйлчилгээ нь таныг эрсдлээс хамгаалах шийдэл юм.



Хувьцаагаа эргүүлэн худалдан авах хоёр дахь хөтөлбөрийг зарлалаа


“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд тус хурлаар компанийн өөрийн гаргасан хувьцааны ханшийг тогтворжуулах зорилгоор хувьцааг үргэлжлүүлэн худалдаж авах шийдвэрийг дахин гаргаж ТУЗ-ийн 21/17 тоот тогтоолоор баталлаа.

2021 оны 06 сарын 30-ны өдрийн хаалтын байдлаар 21/17 тоот тогтоолын хүрээнд нийт 4,556,132 ширхэг хувьцаа халаасалсан байна.

Хувьцааны ханшын мэдээ

“ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлийн амин хөдөлгүүр болох хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс Олон Улсад нийтлэг авч хэрэгжүүлдэг хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулан, хоёр дахь удаагаа хэрэгжүүлж эхлэсэн билээ. Үүний үр дүнд 2021 оны II улиралд компанийн хувьцааны ханшыг тогтворжуулж, хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалсаар байна.

Хувьцааны ханш



2021.II
улиралд:

3.8%


Ханшийн
өсөлт

11.6 сая ширхэг

Нийт арилжаалагдсан
ширхэг

555.2 сая төгрөг

Нийт арилжаалагдсан
үнийн дүн



Хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувь

- Анд Системс ХХК
- Халаасны хувьцаа
- Олон нийт

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд ногдол ашгийг байршууллаа

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 5-ны өдрийн 21/05 тогтоолоор Компанийн 2020 оны цэвэр ашгийн 20%, нэгж хувьцаанд 0.58 төгрөг буюу нийт 447,843,214.92 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан 4,765 хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд ногдол ашгийг байршууллаа.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2021 оны 2 сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 2021 оны 04 сарын 27-ны өдөр ногдол ашгийг нийт хувьцаа эзэмшигчдэдээ тараалаа.

Орон нутгуудад гэрээ байгуулж эхэллээ

Хорио цээрийн дэглэм болон ковидын эрсдэл өндөр байгаа энэ үед хөдөө орон нутгийн харилцагчдадаа цахим зээлийн гэрээ байгуулах боломжийг олгож Дархан-Уул, Увс, Баянхонгор, Булган, Говь-Сүмбэр, Дорнод, Өмнөговь, Төв, Ховд, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Завхан, Архангай, Төв, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Баянхонгор, Өмнөговь, Завхан, Ховд, Архангай гэх мэт аймгуудад хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.





Монгол улсын Тогтвортой санхүүгийн холбоонд нэгдлээ

ЛэндМН нь тогтвортой санхүүгийн зарчим, стандарт хэрэгжүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд хамтран ажиллах зорилгоор ТоС Холбоо / MSFA-нд Үндсэн гишүүнээр нэгдлээ.

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо ("ТоС Холбоо")-г 2017 оны 12 дугаар сард гишүүддээ үйлчилдэг ТББ хэлбэрээр Монголын Банкны Холбоо ("МБХ")-ноос үүсгэн байгуулсан бөгөөд ТоС Холбоо нь Монгол Улсын санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүү, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг манлайлан ажиллах зорилготой юм.

"Тогтвортой санхүүжилт" нь хөрөнгө оруулалт хийх, зээл олгох болон аливаа санхүүгийн шийдвэр гаргахдаа тухайн бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, бууруулах, түүнчлэн хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон эдийн засгийг дэмжсэн төсөл, хөтөлбөрийг дэмжин ажиллах тухай ойлголт юм.

Тогтвортой санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх хариуцлагатай аялалд мөр зэрэгцэн алхах болсондоо ЛэндМН-ийн хамт олон баяртай байна.

03



Харилцагчийн үйлчилгээ



Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 30 ажилчидтайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2021 оны II улирлын турш нийт 60,777 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 99.77 %-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

Улсын онцгой комиссоос гаргасан хөл хорио дэглэмийг чанд баримтлан үйлчилгээний заал ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, цахим хэлбэрээр болон 09:00-16:00 цагийн хооронд хуваарийн дагуу харилцагчийн үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэж байна.

60,777

II улирлын нийт
дуудлага

12 сек

Хүлээлгийн
түвшин

99.77%

Үйлчилгээ амжилттай
хүргэсэн

13,325

Сошиал сувгаар
үйлчилсэн

04

Санхүүгийн үйл ажиллагаа

Санхүүгийн байдлын хураангуй тайлан

/Аудитлагдаагүй/

2021 оны II улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 32.2 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 25.7 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 1.7 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 14.0 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 18.2 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 9.1 тэрбум төгрөг байна.

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021.I	2021.II
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	7.1	1.7
Зээлийн багц (цэврээр)	27.6	25.7
Бусад хөрөнгө	3.7	3.7
Үндсэн хөрөнгө	1.0	0.9
Биет бус хөрөнгө	0.2	0.2
Нийт хөрөнгө	39.6	32.2


Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2021.I	2021.II
Өр төлбөр	22.2	14.0
Эх үүсвэр	19.6	12.5
Бусад өглөг	2.6	1.5
Эздийн өмчийн дүн	17.4	18.2
Хувьцаат капитал	9.3	9.1
Хуримтлагдсан ашиг	8.1	9.1
Нийт өр төлбөр болон эздийн өмч	39.6	32.2

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/


2021 оны II улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 6.4 тэрбум төгрөгт хүрч, 1.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021.I	2021.II
Нийт орлого	3.0	3.4
Хүүгийн зардал	(0.9)	(0.8)
Санхүүгийн цэвэр орлого	2.1	2.6
Банк болон бусад шимтгэл	(0.4)	(0.4)
Шимтгэлийн дараах орлого	1.7	2.2
Эрсдэлийн сангийн зардал	0.3	0
Эрсдэлийн сангийн дараах орлого	2.0	2.2
Боловсон хүчний зардал	(0.6)	(0.5)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.5)	(0.5)
Татварын өмнөх ашиг	0.9	1.2
Татварын зардал	(0.1)	(0.2)
Цэвэр ашиг	0.8	1.0

Шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг (тэрбум төгрөг)



05



Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Монгол улс болоод дэлхий дахинд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн хямрал үргэлжилсээр байгаа энэ цаг үед Монгол улсын засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан хөтөлбөрүүдийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаа.

Ковид-19 цар тахал түүнийг дагасан хямралаас үүдэлтэйгээр иргэдийн ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, зарим нь богиносгосон цагаар ажиллаж сарын орлого нь үлэмж хэмжээгээр багасч буй энэ цаг үед харилцагчдын өмнө тулгарсан санхүүгийн хүндрэлийг хамтдаа шийдвэрлэн ажилласаар байна. Энэ улиралд Монголбанкнаас гаргасан мэдэгдлийн дагуу Зээлийн Мэдээллийн Санд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн түүхтэй харилцагчдадаа 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор зээлээ бүрэн барагдуулсан тохиолдолд зээлийн ангилалд өөрчлөлт оруулах боломжийг олголоо.

Мөн цар тахлаас үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдалд зөв менежментийг хэрэгжүүлэх, урьдчилан таамаглах, хариу арга хэмжээ авах зэрэг нь эрсдэлийн удирдлагын тогтолцоонд шинэ дэвшлийг авчирч, цаашдын компанийн стратегийн хөгжилд нөлөөлөхүйц түлхэц боллоо гэж үзэж байна.

Улсын хэмжээнд Ковид-19 халдварын тархалт улам нэмэгдэж, өдөрт мянга мянгаар шинэ тохиолдол бүртгэгдэж байгаа эрсдэлтэй цаг үед ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс онлайн хэлбэрт шилжүүлж гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж нийт ажилтны 70% нь онлайнаар ажиллаж байгаа ч компанийн үйл ажиллагаа тасралтгүй, найдвартай хэвийн үргэлжилж байна. Нөгөөтэйгүүр цахимаар бүтээмжтэй ажиллах хэв маягт суралцаж, өөрчлөлтөд дасан зохицох, мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг оновчтой удирдах боломж бүрдсэн билээ.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2021 оны II улиралд 1.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 2.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 135.3%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

2021 оны II улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021.I	2021.II
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.3%	50.0%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	46.3%	50.0%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	20%-иас доошгүй	44.0%	56.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас доошгүй	31.7%	12.3%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	5.4%	-14.9%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	59.6%	36.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	36.7%	6.4%

06



Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны II улиралд ээлжит 1, ээлжит бус 2 удаа хуралдаж, нийт 14 тогтоол гаргалаа.

2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 21/02, 21/03 тоот шийдвэрийг үндэслэн Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1, Компанийн дүрмийн 10-р зүйлийн 10.1 хэсэгт заасныг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонголоо.

Компанийн дүрмийн 14-р зүйлийн 14.1-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг батлав. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороод тус бүр 1 удаа хуралдав.

ТУЗ-өөс баталсан тогтоолуудаас онцлон дурдвал:

- Компанийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэв.
- “ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлд нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй “ЛэндБонд”-ыг хоёр дахь удаагаа олон нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэж, өрийн бичгийн ерөнхий нөхцөлийг батлав. Уг тогтоолын хүрээнд бондын анхдагч зах зээлийн арилжаа 2021 оны 6 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд үргэлжилж нийт 505 хөрөнгө оруулагчаас 7,583,500,000 төгрөгийн захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 51.7 хувиар давж биеллээ.
- Компанийн хүрээнд нийтэд санал болгох өрийн бичиг гаргахтай холбоотойгоор “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК болон “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-тай андеррайтерийн болон хамтран ажиллах гэрээ тус тус байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- “Ай Эн Мобайл Нэтворк” ХХК-тай зээл болон зөвлөх үйлчилгээний чиглэлээр, “Дижитал Молл” ХХК-тай зөвлөх үйлчилгээний чиглэлээр тус тус хамтран ажиллах гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- Эх үүсвэр татан төвлөрүүлэх зорилгоор Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцэл хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгож, батлагдсан нөхцөлийн хүрээнд “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-тай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоолуудтай Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/mn>) цахим хуудаснаас дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Холбоо барих: “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг Утас: 9901-8886 имэйл: board@lend.mn



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn